

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/52/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батсайхан
Утас: 70453799, Цахим хаяг: batsaikhanS@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт.....	
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар





**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УВС НУУРЫН АЙ САВЫН УЛСЫН
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР
НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА Б.ОДСҮРЭН
ТАНАА

2022.02.25 № УВА-2022/52/НА-СТА-ТМЗ
танай -ны № -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200250

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>99,300,977.20</u>	<u>106,604,417.20</u>
34	УРЬДЧИЛГАА	8,990,000.00	8,990,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	8,990,000.00	8,990,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	90,310,977.20	97,614,417.20
351	Түүхий эд материал	2,257,500.00	2,257,500.00
35110	Тусгай зориулалттай материал	2,257,500.00	2,257,500.00
354	Хангамжийн материал	86,853,477.20	94,156,917.20
35410	Бичиг хэргийн материал	219,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	86,634,477.20	94,156,917.20
35600	Мал амьтад	1,200,000.00	1,200,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>485,658,280.58</u>	<u>454,452,802.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	485,658,280.58	454,452,802.97
392	Биет хөрөнгө	470,091,780.67	439,102,136.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	328,766,546.00	328,766,546.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-20,319,734.00	-31,117,848.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	141,433,503.50	118,605,943.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	-55,387,096.60	-52,472,640.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	115,854,226.06	82,688,436.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-61,133,794.09	-26,226,609.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,061,088.09	24,199,788.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,618,125.28	-8,770,146.78
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	2,000,000.00	2,000,000.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-1,359,999.98	-1,440,000.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,118,000.00	9,118,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,322,833.03	-6,249,332.99
393	Биет бус хөрөнгө	15,566,499.91	15,350,666.68
39301	Програм хангамж	730,000.00	730,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-247,500.09	-463,333.32
39303	Бусад биет бус хөрөнгө	15,084,000.00	15,084,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>584,959,257.78</u>	<u>561,057,220.17</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,493,000.00</u>	<u>1,672,540.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,493,000.00	1,672,540.00
413	Өглөг	1,493,000.00	1,672,540.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	732,500.00	1,672,540.00
4136	Бусад өглөг	760,500.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	760,500.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>583,466,257.78</u>	<u>559,384,680.17</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	583,466,257.78	559,384,680.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	263,231,402.00	263,231,402.00

51101	Өмч: - төрийн	263,231,402.00	263,231,402.00
512	Хуримтлагдсан үр дүн	299,057,273.81	274,975,696.20
51210	Өмнөх үеийн үр дүн	237,143,560.19	237,143,560.19
51220	Тайлант үеийн үр дүн	61,913,713.62	37,832,136.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,177,581.97	21,177,581.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	584,959,257.78	561,057,220.17

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	315,713,150.00	391,706,218.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,182,200.00	16,281,118.54
120	Нийтлэг татварын бус орлого	5,182,200.00	16,281,118.54
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,018,000.00	16,281,118.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	7,751,080.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,000.00	8,530,038.54
120009	Бусад орлого	1,164,200.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	310,530,950.00	375,425,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	268,178,200.00	361,826,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	268,178,200.00	361,826,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,352,750.00	13,599,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,264,750.00	13,599,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,088,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	290,168,655.25	411,834,606.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	290,168,655.25	411,834,606.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	290,168,655.25	407,220,899.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168,512,759.00	231,643,761.40
210101	Үндсэн цалин	123,270,373.00	168,386,647.00
210102	Нэмэгдэл	37,549,262.00	58,673,794.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,665,494.00	4,583,320.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,027,630.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,686,477.00	31,545,082.32
210201	Тэтгэврийн даатгал	14,473,610.00	22,334,147.92
210202	Тэтгэмжийн даатгал	1,677,390.00	2,316,598.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,341,833.00	1,797,840.08
210204	Ажилгүйдлийн даатгал	290,341.00	463,298.20
210205	Эрүүл мэндийн даатгал	2,903,303.00	4,633,198.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,924,204.00	18,614,240.00
210301	Гэрэл, цахилгаан	513,240.00	2,188,600.00
210302	Түлш, халаалт	8,785,260.00	15,618,240.00
210303	Цэвэр, бохир ус	625,704.00	807,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,319,329.00	20,079,850.00
210401	Бичиг хэрэг	1,011,560.00	835,600.00
210402	Тээвэр, шатахуун	11,414,780.00	16,132,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,399,489.00	1,570,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	129,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	373,500.00	1,411,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	318,500.00	393,500.00
210604	Урсгал засвар	318,500.00	393,500.00

2107	Томилолт, зочны зардал	4,876,500.00	5,071,000.00
210702	Дотоод албан томилолт	4,876,500.00	5,071,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,103,463.00	64,831,689.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,222,031.00	64,161,767.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	188,582.00	82,772.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	426,500.00	350,000.00
210807	Газрын төлбөр	00.00	150,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,427,423.25	35,041,776.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	998,800.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,100,500.00	749,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,328,123.25	34,292,326.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	4,613,707.28
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	4,613,707.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,613,707.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	25,544,494.75	-20,128,388.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	870,833.43	3,953,189.53
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	870,833.43	3,953,189.53
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145- 225)	-870,833.43	-3,953,189.53
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	24,673,661.32	-24,081,577.61

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	437,763,000.00	383,176,180.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,000,000.00	7,751,080.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,000,000.00	7,751,080.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,000,000.00	7,751,080.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	7,751,080.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	433,763,000.00	375,425,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	373,626,600.00	361,826,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	373,626,600.00	361,826,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,136,400.00	13,599,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	55,262,200.00	13,599,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,874,200.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	423,340,800.00	383,176,180.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	423,340,800.00	383,176,180.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	391,413,628.56	378,562,472.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,581,846.95	230,866,115.40
210101	Үндсэн цалин	155,027,100.00	165,618,181.00
210102	Нэмэгдэл	59,319,946.95	60,664,614.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,145,500.00	4,583,320.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,089,300.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,993,249.61	31,273,988.32
210201	Тэтгэврийн даатгал	19,564,286.93	22,007,597.92
210202	Тэтгэмжийн даатгал	2,257,400.00	2,316,598.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,805,800.00	1,853,296.08
210204	Ажилгүйдлийн даатгал	394,134.80	463,298.20
210205	Эрүүл мэндийн даатгал	3,971,627.88	4,633,198.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,119,792.00	16,941,700.00
210301	Гэрэл, цахилгаан	1,381,790.00	2,188,600.00
210302	Түлш, халаалт	14,929,720.00	13,945,700.00
210303	Цэвэр, бохир ус	808,282.00	807,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,012,279.00	20,612,400.00
210401	Бичиг хэрэг	1,266,000.00	594,700.00
210402	Тээвэр, шатахуун	12,641,280.00	13,933,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,123,399.00	1,700,500.00
210404	Ном, хэвлэл	22,200,000.00	2,198,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	781,600.00	2,186,100.00
2105	Нормативт зардал	00.00	224,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	224,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	493,200.00	1,066,500.00
210602	Тавилга	117,800.00	00.00

210604	Урсгал засвар	375,400.00	1,066,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,240,500.00	5,071,000.00
210702	Дотоод албан томилолт	6,240,500.00	5,071,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,911,961.00	71,700,619.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,754,729.00	71,030,697.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	188,582.00	82,772.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	551,500.00	350,000.00
210807	Газрын төлбөр	150,800.00	150,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,060,800.00	806,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,255,800.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,805,000.00	806,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,927,171.44	4,613,707.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,058,741.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,050,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,008,741.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,868,430.44	4,613,707.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,868,430.44	4,613,707.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,422,200.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,422,200.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,422,200.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,422,200.00	00.00
223001	Бусад хөрөнгө	8,990,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,432,200.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-14,422,200.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	263,231,402.00	21,177,581.97	237,143,560.19	521,552,544.16
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	263,231,402.00	21,177,581.97	237,143,560.19	521,552,544.16
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	24,673,661.32	24,673,661.32
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,231,402.00	21,177,581.97	299,057,273.81	583,466,257.78
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	263,231,402.00	21,177,581.97	299,057,273.81	583,466,257.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	263,231,402.00	21,177,581.97	299,057,273.81	583,466,257.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-24,081,577.61	-24,081,577.61
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,231,402.00	21,177,581.97	274,975,696.20	559,384,680.17

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	365,826,100.00	369,577,180.00	-3,751,080.00	101.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	365,826,100.00	369,577,180.00	-3,751,080.00	101.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	365,826,100.00	364,990,522.72	835,577.28	99.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,658,700.00	230,866,115.40	792,584.60	99.66
210101	Үндсэн цалин	165,620,300.00	165,618,181.00	2,119.00	100.00
210102	Нэмэгдэл	60,892,900.00	60,664,614.40	228,285.60	99.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,145,500.00	4,583,320.00	562,180.00	89.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,274,000.00	31,273,988.32	11.68	100.00
210201	Тэтгэврийн даатгал	22,007,600.00	22,007,597.92	2.08	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,316,600.00	2,316,598.04	1.96	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,853,300.00	1,853,296.08	3.92	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	463,300.00	463,298.20	1.80	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,633,200.00	4,633,198.08	1.92	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,941,700.00	16,941,700.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,188,600.00	2,188,600.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	13,945,700.00	13,945,700.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	807,400.00	807,400.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,773,900.00	15,773,900.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	350,700.00	350,700.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	13,005,000.00	13,005,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,700,500.00	1,700,500.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	717,700.00	717,700.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,683,200.00	2,657,000.00	26,200.00	99.02
210702	Дотоод албан томилолт	2,683,200.00	2,657,000.00	26,200.00	99.02
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,438,400.00	67,421,619.00	16,781.00	99.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,768,300.00	66,751,697.00	16,603.00	99.98
210803	Даатгалын үйлчилгээ	64,400.00	64,350.00	50.00	99.92
210804	Тээврийн хэрэгслийн татвар	82,800.00	82,772.00	28.00	99.97
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	150,900.00	150,800.00	100.00	99.93
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,200.00	56,200.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	56,200.00	56,200.00	0.00	100.00

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	365,826,100.00	369,577,180.00	-3,751,080.00	101.03
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	361,826,100.00	361,826,100.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	361,826,100.00	361,826,100.00	0.00	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,000,000.00	7,751,080.00	-3,751,080.00	193.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	7,751,080.00	-3,751,080.00	193.78

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		13,571,950.00	-13,571,950.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		13,571,950.00	-13,571,950.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		13,571,950.00	-13571950.00	
2104	Хангамж, бараа материалын зардал		4,838,500.00	-4838500.00	
210401	Бичиг хэрэг		244,000.00	-244000.00	
210402	Тээвэр, шатахуун		928,100.00	-928100.00	
210404	Ном, хэвлэл		2,198,000.00	-2198000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,468,400.00	-1468400.00	
2105	Нормативт зардал		224,000.00	-224000.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		224,000.00	-224000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,066,500.00	-1066500.00	
210604	Урсгал засвар		1,066,500.00	-1066500.00	
2107	Томилолт, зочны зардал		2,414,000.00	-2414000.00	
210702	Дотоод албан томилолт		2,414,000.00	-2414000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,279,000.00	-4279000.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,279,000.00	-4279000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		749950.00	-749950.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		749,950.00	-749950.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		13,571,950.00	-13,571,950.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		13,571,950.00	-13,571,950.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		13,571,950.00	-13,571,950.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь дархан цаазат газрын хамгаалалт, байгалийг унаган төрхийг хойч үедээ өвлүүлэн үлдээхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дотоод аудитын хороо Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2019, 2020, 2021 оны 1 дүгээр улирлын төсвийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүн, тайлагналт, хууль, тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийжээ. Уг аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Жолоочийн замын хуудсыг бүрэн бичиж тооцоог “Жишиг норм батлах тухай” Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дүгээр тушаалыг үндэслэн жолоочийн тооцооны хуудасны тооцоог жишиг нормын дагуу шатахуун зарцуулалтыг улирлын болон бүсийн өөрчлөлтүүдийг нарийвчлан зөв тооцож хэвших.
2. Гэрээт байгаль хамгаалагчийн хамтран ажиллах гэрээг улирлаар байгуулж улирал бүр дүгнэж гүйцэтгэсэн ажлыг тайлагнаж хэвших.

3. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг сайжруулж, аудитын явцад илэрсэн зөрчилд дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах.
4. Орон тоог батлагдсан хэмжээнд ажиллуулах, цалингийн сангийн тооцооллыг нарийвчлан гаргах.
5. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47, 2017 оны 29, Засгийн газрын 2002 оны 200, 2014 оны 147, 2021 оны 43 дугаар тогтоолууд болон “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 оны дугаар тогтоолыг биелүүлэн ажиллаж байгууллагын санхүүгийн сахилга батыг сайжруулан, өгсөн зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулах.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 411.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,902.0 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа	8,990.0	8,990.0	0.0
Бараа материал	90,310.9	97,614.4	7,303.5
Үндсэн хөрөнгө	485,658.3	454,452.8	-31,205.5
Нийт хөрөнгө	584,959.2	561,057.2	-23902.0
Өр төлбөр	1,493.0	1,672.5	179.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	583,466.2	559,384.7	-24081.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	584,959.2	561,057.2	-23902.0

Бараа материалын дансны үлдэгдэл 97,614.4 мянган төгрөг болж 7,303.5 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 454,452.8 мянган төгрөг болж 31,205.5 мянган төгрөгөөр буурсан нь авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг акталж устгаснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 5,160.5 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан, 1,738.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авснаар нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 559,384.7 мянган төгрөг болж 23,902.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн алдагдалтай гарснаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 75,993.1 мянган төгрөгөөр буюу 19.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан акталж, устгасан үндсэн хөрөнгө, бараа материал байна.

Нийт зардал өмнөх оноос 121,665.9 мянган төгрөгөөр буюу 29.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэл, түлш халаалт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 325,292.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 325,292.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 40,533.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 365,826.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь гэрээт байгаль хамгаалагчийн орон тоог нэмэгдүүлж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 365,826.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 361,826.1 мянган төгрөгийг улсын төсвөөс 4,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 361,826.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 7,751.1 мянган төгрөг, нийт 369,577.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 369,577.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 369,577.2 мянган төгрөг буюу 100 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13,599.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэргийн зардалд 244.0 мянга, тээвэр шатахууны зардалд 928.1 мянга, ном хэвлэл 2,198.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зардал 1,468.4 мянга, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 224.0 мянга, урсгал засвар 1,066.5 мянга, дотоод албан томилолт 2,414.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 4,279.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 749.9 мянга, нийт 13,571.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг хамруулан шалгасан.

Тус байгууллагын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй тул түүвэрт хамруулж Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгах аар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /С.БАТСАЙХАН/

2022 оны 02 сарын 25-ний өдөр